



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.12.22 № 03/10734

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2014 оны 09 дүгээр сарын 17-ноос 2014 оны 09 дугаар сарын 24-ны өдрүүдэд тус дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилттэй танилцлаа.

Үйл ажиллагаандаа Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг удирдлага болгон дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхчулуун нартай уулзаж ярилцан нөхцөл байдлыг танилцуулж ажилласан.

Тус дүүргийн Тамгын газар, харьяа хэлтэс агентлагуудын төлөөлөлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг таниулах мэдээлэл бүхий 15 асуулттай мэдлэг сорих тест боловсруулан ажиллуулж, оролцооны аргыг ашиглан үр дүнд чиглэсэн мэдээлэл өгөх хэлбэрээр зохион байгуулсан сургалтад 88, "Авлига, ашиг сонирхлын зөрчил ба ил тод байдал" сэдвээр зохион байгуулан сургалтад 258 төрийн албан хаагч тус тус оролцлоо.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мэдээллийн ил тод байдал хангалтгүй байсан бөгөөд босоо удирдлагатай төрийн байгууллагуудын мэдээ, мэдээллийн ил тод байдал харьцангуй зохих түвшинд байна.

Иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, хэрэгцээ хангахуйц мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх, тухайлбал, худалдан авах ажиллагаа, хүний нөөцтэй холбоотой мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын цахим хуудсаар мэдээлэх санаачилга дутмаг байна.

Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан авлигын эсрэг үйл ажиллагаатай холбогдох бүртгэл хөтлөлтүүдийг зөвхөн хөрөнгө, орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, түүнтэй холбоотой мэдээ тайлан гаргах

төдийгээр хязгаарлаж, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журам /Эрх бүхий албан тушаалтан/-аар хүлээлгэсэн нийтлэг үүргүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн албыг цэвэр, шударга, тэгш зарчмаар явуулах удирдлагын хүчин чармайлт нэн дутмаг, хууль ёсыг дээдлэн сахих ёс зүй бүрэн төлөвшөөгүй гэж дүгнэж үзэхээр байгаа тул дүүргийн удирдах албан тушаалтнуудад тусгайлсан авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Дүүргийн удирдлагаас авлигын эсрэг хууль тогтоомжоор авлигаас ангид байхад чиглэсэн төрийн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэсэн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх талаарх санаачилга сул байгаагаас Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэрүүд ихээр гаргасан байна.

Ялангуяа албан тушаалтнууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд болон үүсэхээс сэргийлсэн мэдэгдэл, тайлбараа зохих байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх үүргийг хэрэгжүүлж хэвшээгүйн улмаас албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, давуу байдал олгох, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулах, хандив бэлэг авах, өгөх зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчлүүдийн шинжийг агуулсан шийдвэрүүд гаргасны заримаас дурдвал:

1.Засаг даргын 2013 оны 493 дугаар захирамжаар 53.750.000 төгрөг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/206 дугаар тогтоолоор 36.550.000 төгрөг, нийт 90.300.000 төгрөгийг Тайландын вант улсын Бангкок хотод зохиогдох “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын анхдугаар чуулга уулзалт”-д оролцож, туршлага судлахаар 42 хүн тус улсад албан томилолтоор ажиллахад зарцуулсан нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалтын бусаар зарцуулсан гэж үзэхээр байна. Учир нь тухайн чуулга уулзалт 2013 оны 12 дугаар сарын 26-наас 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Тайланд улсын Бангкок улсад зохион байгуулагдсан эсэх сургалтын хөтөлбөр нь юу болох, ямар туршлага судалсан болох нь тодорхойгүй, зөвхөн урилга гэх тайланд хэл дээрх 1 хуудас баримт, тус улсад аялахдаа авахуулсан бололтой фото зураг, Тайланд улс руу явсан тухай ИТХ-ын ажлын албаны ажилтны 1 хуудас илтгэх хуудаснаас өөр баримт байхгүй байв. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасныг;

2.Дүүргийн Засаг даргын 2013 оны 130 дугаар захирамжаар Онцгой комиссын ажлын хэсэг, ажиллах журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан гишүүдийг үнэмлэхжүүлэх, хэвлэмэл хуудас, ажлын дэвтрийг хэвлүүлэх зардал болон гишүүдийн ажлын хувцасны болон холбогдох бусад зардлыг баталж нийт 14.394.000 төгрөгийг Засаг даргын нөөц

сангаас гаргахаар төсөвлөж 11.105.000 төгрөгөөр өвөл, зуны хувцас бэлтгэсэн нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалтын бусаар зарцуулсан гэж үзэхээр байна.

Уг асуудал нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 15-р зүйлийн "Энэ журмын 2.1, 2.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно" заалтыг тус тус зөрчиж байна.

3.Засаг даргын 2014 оны А/246 дугаар захирамжаар Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх, зохион байгуулахтай холбогдуулан гарах зардал 3.490.000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргасан байна. Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 15-р зүйл "Энэ журмын 2.1, 2.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхчулуун нь 2013 оны 149, 2013 оны 78, 2013 оны 229, 2014 оны А/61, 2014 оны А/112 дугаар тушаалууд гаргаж өөрөө өөртөө удаа дараа урамшуулал олгосон байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу "ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн Мэдэгдэл" гаргах үүргээ хэрэгжүүлээгүй байх бөгөөд мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "...өөрийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргахыг хориглоно", мөн Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь ... үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална." гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзэхээр байна.

5.Татварын хэлтсийн даргын 2014 оны Б/114 дүгээр тушаалаар Ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байх бөгөөд "Монгол консалтинг" ХХК-ны захирал Х.Тунгалагмаа гишүүнээр ажиллаж байна. Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2014 оны А/200 дугаар тушаалын 2 дугаар хавсралт "Үндэсний татварын албаны Ёс зүйн хорооны ажиллах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дэх "Аймаг, нийслэл, дүүрэг татварын /газар/ хэлтсийн дэргэдэх Ёс зүйн салбар ... хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо хамт олны саналыг авах бөгөөд хамгийн олон санал авсан алба хаагчдаас саналын эрэмбээр сонгож тухайн татварын албаны даргын тушаалаар баталгаажуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Татварын хэлтсийн даргын 2013 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 73 дугаар “Шагнал цалин олгох тухай”, 09 дүгээр сарын 20 ны өдрийн 74 дүгээр “Урамшуулал олгох тухай” тушаал гаргахдаа Монгол улсын “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-ийг үндэслэл болгосон байх бөгөөд тус хууль нь 2011 оны 12 дугаар сарын 23 өдрийн “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай” Монгол улсын хуулиар 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хүчингүй болсон байна.

Мөн дээрх урамшууллыг олгох тухай хэлтсийн даргын зөвлөлийн хуралд зөвлөлийн гишүүн Татвар хураалтын тасгийн дарга, ТУАБ Сү. Оюунгэрэл, Татвар хураалтын тасгийн ТУАБ Ч.Марина нар оролцон нийгмийн асуудал шийдвэрлүүлэхэд Сү.Оюунгэрэл 6.000.000 /зургаан сая/ төгрөг, Ч.Марина 6.000.000 /зургаан сая/ төгрөг, Урамшуулалт цалин олгоход Сү.Оюунгэрэл 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөг, Ч.Марина 900.000 /өсөн зуун мянга/ төгрөгийн урамшуулал авсан нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

6.Эрүүл мэндийн нэгдлийн дарга Ш.Хажидмаа нь 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 229 дугаар тушаал, 2014 оны 1 дүгээр сарын 20-ний өдрийн 25 дугаар тушаалаар өөрөө өөртөө “нэмэгдэл, мөнгөн урамшуулал” олгосон байна. Уг үйлдэл нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймээс дээрх зөрчил, дутагдалд дүгнэлт хийж, дүүргийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ үү.

1.Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг бодит үр дүнд хүрэхэд чиглэсэн агуулгаар боловсруулж, хэрэгжилт болон хугацаанд нь тогтмол хяналт тавьж ажиллах;

2.Төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсыг иргэдэд үнэн зөв мэдээлэл хүргэх, иргэд дүүргийн үйл ажиллагааг хөндлөнгөөс хянах бололцоотой болгон сайжруулах, Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын цахим хуудсыг дүгнэх зорилгоор гаргасан үзүүлэлтэд нийцүүлэн бүтэц, агуулгын өөрчлөлтийг хийж, байнгын тасралтгүй үйл ажиллагааг нь хангах чиглэлээр арга хэмжээ авах;

3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдээс мэдээлэл хүлээж авах ажлыг зохион байгуулж, хэвшүүлэх;

4.Орон нутгийн газар зохион байгуулалт, газар олголт, иргэдэд өмчлүүлэх болон эзэмшүүлэх боломжтой газрын талаар улирал тутамд мэдээ мэдээллийн самбараар дамжуулж олон нийтэд мэдээлж байх, газар эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод болгох;

5.Иргэдэд мэдээлэл хүргэх тодорхой, тогтсон арга хэрэгсэлтэй болох, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагааг хангах, төсөв, санхүүгийн тайлангийн талаар иргэдэд мэдээлэхдээ энгийн хялбар аргачлалаар мэдээлэх;

6.Төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын мэдээллийн самбарт үйлчилгээний төлбөр хураамжийн эрх зүйн үндэслэл жагсаалтын талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж, энэхүү жагсаалтаас гадуур аливаа төлбөр төлөх ёсгүй тухай тодорхой мэдээлсэн байх зэрэг болно.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулан, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллахыг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтын дагуу Зөвлөмж болгож байна.

Зөвлөмжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2015 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ